



# Зөвлөмжийн Цуврал

## ЗЦ92-3

Нэмэлт, өөрчлөлт 1 (2)

**Аюултай барааны баглаа  
боодлын иж бүрдлийг зөвшөөрөх**

**2016 оны 6 сарын 8**

### **Ерөнхий зүйл**

Иргэний нисэхийн ерөнхий газрын Зөвлөмжийн цуврал (ЗЦ) нь холбогдох дүрмийн шаардлагыг хангаж байгааг Дарга хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр илэрхийлсэн стандарт, туршлага, журмуудыг агуулсан байдаг.

Хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр нь Даргад дүрмийн шаардлагыг хангаж байгааг нотлох цорын ганц хэлбэр биш юм. Хүлээн зөвшөөрөхүйц шинэ стандарт, туршлага, эсхүл журам гарч ирсэн тохиолдолд холбогдох ЗЦ-д нэмж оруулах болно.

Түүнчлэн, энэхүү ЗЦ нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулсан болно. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

### **Зорилго**

Энэхүү ЗЦ нь ИНЕГ-аас Аюултай барааны баглаа боодлын иж бүрдэлд зөвшөөрөл олгоход ИНД-92-ын шаардлагыг биелүүлэх аргачлалыг агуулсан болно.

### **Хамаарах дүрмүүд**

Энэхүү ЗЦ нь ИНД-92, ИНД-92.53-д шууд хамаарна.

### **Өөрчлөлтийн мэдэгдэл**

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

ЗЦ92-3-ыг монгол болон англи хэл дээр боловсруулсан бөгөөд хэрэв эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

ЗЦ92-3-ыг NZ AC101-1-ийн 2015 оны 09 сарын 24-ний өөрчлөлт 1-д үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

<b>Аюултай барааны баглаа боодлын иж бүрдлийн зөвшөөрөл.....</b>	<b>3</b>
1. Өмнөтгөл.....	3
2. Баглаа боодлын иж бүрдлийн зөвшөөрөл.....	3
3. Зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага .....	3
4. Баглаа боодлын иж бүрдэлд зөвшөөрөл авах хүсэлт .....	3
5. Зөвшөөрөл авахад тавих шаардлага.....	3
6. Баглаа боодлын иж бүрдлийн төрөл .....	4
7. Баглаа боодлын иж бүрдлийн тест .....	4
8. Тестийн тайлан.....	4
9. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа .....	5
10. Техникийн үзүүлэлтийн тэмдэглэгээ .....	5
11. Зөвшөөрлийн код .....	7
<b>Хавсралт 1.....</b>	<b>8</b>
Техникийн үзүүлэлтийн тэмдэглэгээний жишээ .....	8
(a) Зөвхөн ИНЕГ-аас зөвшөөрсөн нийлмэл баглаа боодол. ....	8
(b) Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны аюултай барааны дүрмийн Хавсралт Е.2-т заасан, ИНЕГ-аас зөвшөөрсөн нийлмэл баглаа боодлын тестийн байгууллага .....	8

## Аюултай барааны баглаа боодлын иж бүрдлийн зөвшөөрөл

### 1. Өмнөтгөл

1.1 Энэхүү ЗЦ нь аюултай барааны баглаа боодлын иж бүрдлийн үйлдвэрлэгч болон аюултай барааг тогтмол илгээгч нарт зориулагдсан болно.

1.2 ЗЦ нь Иргэний нисэхийн ерөнхий газар (ИНЕГ)-аас баглаа боодолд зөвшөөрөл олгох шаардлагатай болохыг заасан ба зөвшөөрлийн үе шатуудыг агуулсан.

### 2. Баглаа боодлын иж бүрдлийн зөвшөөрөл

2.1 ИНЕГ-аас зөвшөөрөл авах шаардлагатай аюултай барааны баглаа боодлын иж бүрдэл нь дараах шаардлагыг хангасан байна:

- (a) ICAO-гийн Техникийн зааварчилгааны дагуу тест хийгдсэн байх,
- (b) Монгол Улсад үйлдвэрлэгдсэн байх.

### 3. Зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага

3.1 Аюултай барааны баглаа боодлын иж бүрдэлд зөвшөөрөл олгох эрх бүхий зохих байгууллага нь:

- a) Ангилал-7 аюултай барааны баглаа боодлын иж бүрдлийн хувьд Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- b) Ангилал-7-гоос бусад аюултай барааны баглаа боодлын иж бүрдлийн хувьд Иргэний нисэхийн ерөнхий газар.

### 4. Баглаа боодлын иж бүрдэлд зөвшөөрөл авах хүсэлт

4.1 Ангилал-7 аюултай барааны баглаа боодлын иж бүрдэлд зөвшөөрөл авах хүсэлтийг:

Монгол улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 12-р байр, Улаанбаатар, Монгол улс

Утас: +976-51-264786

E-mail: [info@inspection.gov.mn](mailto:info@inspection.gov.mn)-д

4.2 Ангилал-7-оос бусад аюултай барааны баглаа боодлын иж бүрдэлд зөвшөөрөл авах хүсэлтийг:

Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба

Иргэний нисэхийн ерөнхий газар-т

17120, Буянт-Ухаа 34, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар, Монгол улс

Утас: +976-28-2019

Факс: +976-7004-6562 тус тус гаргана.

### 5. Зөвшөөрөл авахад тавих шаардлага

5.1 Зөвшөөрөл авах хүсэлтэд энэ зүйлийн 8-д заасан мэдээллийг багтаасан тестийн тайланг хавсаргасан байна.

## **6. Баглаа боодлын иж бүрдлийн төрөл**

**6.1** Баглаа боодлын иж бүрдэл гэдэг нь тухайн бодис, эд зүйлийг шууд агуулж байгаагаас бусад агуулах савыг хэлнэ. Хосолсон баглаа боодлын иж бүрдэл гэдэг нь зөөлөвч материал, эсхүл шингээх материал, дотоод баглаа боодлын иж бүрдэл мөн бодис, эд зүйлийг хөдөлгөөнгүй байрлуулах материал, ивүүргийг хэлнэ.

**6.2** Нийлмэл баглаа боодлын иж бүрдэл нь нэг, эсхүл хэд хэдэн дотоод баглаа боодлын иж бүрдэл бүхий аюултай бодис болон эд зүйлийг гадуур баглаа боодлын иж бүрдэлд зөвхөн тээвэрлэхэд зориулан нэгтгэсэн байна.

**6.3** Хосолсон баглаа боодол гэдэг нь дотоод болон гадуур баглаа боодлын иж бүрдлийг ашиглан нэг цогц баглаа боодол болгосон байхыг хэлнэ. Энэ нь аюултай барааг агуулах, хадгалах, тээвэрлэх, юүлэх нэг нэгж болно.

**6.4** Дан баглаа боодлын иж бүрдэлд аливаа өөр баглаа боодлын иж бүрдэл шаардлагагүй бөгөөд агуулах, хадгалах, тээвэрлэх, юүлэх үүргийг дангаараа гүйцэтгэнэ.

## **7. Баглаа боодлын иж бүрдлийн тест**

**7.1** Тест шаардлагатай баглаа боодлын иж бүрдлийг тестийг ICAO-гийн Техникийн зааварчилгааны Бүлэг 6-т заасан шаардлагын дагуу хийнэ.

**7.2** Тест нь тээвэрлэлтэд бэлтгэгдсэн, дотоод болон хосолсон баглаа боодлын иж бүрдэл дээр хийгдэнэ.

**7.3** Баглаа боодлын иж бүрдлийн тест хийх лаборатори, тухайн баглаа боодлын иж бүрдэл нь аюултай бараанд зориулагдсан гэдгийг мэдэж байх нь чухал бөгөөд тестийг ICAO-гийн Техникийн зааварчилгааны дагуу хийнэ.

**7.4** Шингэн аюултай бараа агуулах нийлмэл баглаа боодлын иж бүрдлийн тестийн тайланд дотоод баглаа боодлын иж бүрдэл нь ICAO-гийн Техникийн зааварчилгааны Бүлэг 6 Хэсэг 4-т заасан даралтын шаардлагыг хангаж байгааг баталгаажуулна.

**7.5** Ангилал-1 аюултай барааны хувьд тестийн тайланд баглаа боодлын иж бүрдлийн үйлдвэрлэгчээс олгосон гэрчилгээг хавсаргасан байна.

**7.6** Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны аюултай барааны дүрмийн Хавсралт E.2-т заасан тестийн лабораториудад тестийг хийнэ.

## **8. Тестийн тайлан**

**8.1** Баглаа боодлын иж бүрдэлд зөвшөөрөл авах хүсэлтэд дараах мэдээллийг багтаасан тестийн тайланг хавсаргасан байна:

- (a) тест хийсэн газрын нэр, хаяг;
- (b) шаардлагатай тохиолдолд, хүсэлт гаргагчийн нэр, хаяг;
- (c) тестийн тайланд оноосон таних дугаар;
- (d) тестийн тайлангийн он сар өдөр;
- (e) баглаа боодлын иж бүрдлийн үйлдвэрлэгч;
- (f) баглаа боодлын иж бүрдлийн төрлийн тайлбар (жишээлбэл: хэмжээ, материал, битүүмжлэх арга, зузаан зэрэг);

- (g) үйлдвэрлэсэн арга (жишээлбэл үлээлгэж хэлбэрт оруулсан); бүдүүвч зураг, фото зураг, эсхүл аль аль нь
- (h) багтаамжийн хязгаар;
- (i) тестийн онцлог (жишээлбэл шингэний наалдамхай чанар, харьцангуй нягтаршил, хатуу биетийн материалын ширхгийн хэмжээ);
- (j) тестийн бүрэн тодорхойлолт ба үр дүн;
- (k) гарын үсэг, нэр ба албан тушаал;
- (l) мэдэгдэл:
  - (i) баглаа боодлын иж бүрдлийн тээвэрлэлтэд бэлтгэгдсэн байдлыг ИСАО-гийн Техникийн зааварчилгааны холбогдох шаардлагын дагуу, эсхүл *НҮБ-ийн аюултай бараа тээвэрлэх зөвлөмжийн Хэсэг 9-ийн* холбогдох шаардлагын дагуу тест хийсэн гэдгийг;
  - (ii) эд зүйл болон бодисыг баглаж боох аргачлал, дотоод баглаа боодлын иж бүрдлийн хэмжээ болон төрлийг.

## 9. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа

**9.1** Хэрэв тестийн тайлангаар баглаа боодлын иж бүрдэл нь шаардлага хангасан гэж үзвэл ИНЕГ, эсхүл МХЕГ-аас баглаа боодлын иж бүрдлийг 5 хүртэл жилийн хугацаагаар зөвшөөрнө.

**9.2** Зөвшөөрөл нь зөвхөн тухайн тест хийгдсэн баглаа боодлын иж бүрдэлд олгогдоно. Хэрэв баглаа боодлын иж бүрдлийн шинж чанар өөрчлөгдсөн, эсхүл баглаа боодлын иж бүрдлийг үйлдвэрлэх аргачлалд аливаа өөрчлөлт орсон, эсхүл аль алинд нь өөрчлөлт орсон бол баглаа боодлыг дахин тест хийж тусад нь зөвшөөрнө.

**9.3** Анхны зөвшөөрлөөс хойш дараагийн 5 жилийн зөвшөөрлийн талаар хүсэлт гаргахдаа дараах нотлох баримтыг холбогдох байгууллагад ирүүлнэ. Үүнд:

- (a) Баглаа боодлын иж бүрдлийн шинж чанарт анхны тестээс хойш өөрчлөлт ороогүй ба үйлдвэрлэлийн аргад өөрчлөлт ороогүй гэдгийг;
- (b) Тухайн баглаа боодлын иж бүрдлийн тестэд өөрчлөлт ороогүй.

**9.4** Дээрх нөхцөлүүд хангагдаагүй тохиолдолд баглаа боодлын иж бүрдлийг зохих лабораторид хүргүүлж дахин тестэд оруулж зөвшөөрүүлэх шаардлагатай.

## 10. Техникийн үзүүлэлтийн тэмдэглэгээ

**10.1** Баглаа боодлын иж бүрдлийг зөвшөөрөх явцын хэсэг болох техникийн үзүүлэлтийн тэмдэглэгээг ИНЕГ-аас олгоно.


**10.2** Ангилал 2-т хамаарах зарим хий, Ангилал-7 цацраг идэвхт бодис, Ангилал-9-д хамаарах зарим баглаа боодлын иж бүрдлээс бусад бүх дан баглаа боодлын иж бүрдэл, нийлмэл баглаа боодол болон хосолсон баглаа боодлын гадуур баглаа боодлын иж бүрдэлд техникийн үзүүлэлтийн тэмдэглэгээг тавина. Тэмдэглэгээ нь ашиглалтын явцад тэсвэртэй бөгөөд гаргацтай байна. Тэмдэглэгээг баглаа боодлын хэмжээнд тохирсон, ил харагдахуйц байдлаар тавина.

**10.3** Бохир жин нь 30кг-аас их илгээмжийн хувьд тэмдэглэгээ нь илгээмжийн дээд талд, эсхүл хажуу талд тавигдсан байх шаардлагатай.

**10.4** Үсэг, тоо, тэмдэгтүүд хамгийн багадаа 12мм өндөртэй, 30литр, эсхүл 30кг-аас бага хэмжээтэй илгээмжийн хувьд 6мм-ээс багагүй байх шаардлагатай. 5литр, эсхүл 5кг болон түүнээс бага хэмжээтэй илгээмжийн хувьд үсэг, тоо болон тэмдэгт нь тохиромжтой хэмжээтэй байх ёстой.

**10.5** Монгол Улсад үйлдвэрлэгдэж ИНЕГ-аас зөвшөөрсөн баглаа боодлын иж бүрдлийн тэмдэглэгээ нь дараах бүрдэлтэй байна:

- (i) НҮБ-ийн баглаа боодлын иж бүрдлийн тэмдэгт;
- (ii) Баглаа боодлын иж бүрдлийн төрлийг тодорхойлсон код
- (iii) 2 хэсгээс бүрдсэн код:
  - (i) тестийн хариугаар савлах Группыг тодорхойлсон үсэг:  
савлах Групп I, II болон III бол 'X'  
савлах Групп II болон III бол 'Y'  
савлах Групп III бол 'Z';
  - (ii) шингэн зүйлийг агуулах дан баглаа боодлын иж бүрдлийн хувьд тестийн дүнгээр гарсан, бүхэл аравтын бутархай бүхий тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэн харьцангуй нягтаршлын хэмжээ. Харьцангуй нягтаршлын хэмжээ нь 1.2-оос ихгүй бол хамаарахгүй, эсхүл Хатуу биет болон дотоод баглаа боодлын иж бүрдлийг агуулах бол тестийн дүнд гарсан хамгийн их бохир жингийн хэмжээг кг-аар зааж өгнө.
- (iv) Шингэн зүйлийг агуулах дан баглаа боодлын иж бүрдлийн хувьд шингэний даралтын хэмжээг хамгийн ойрын 10kPa-аар илэрхийлсэн үр дүнг; эсхүл Хатуу биет болон дотоод баглаа боодлын иж бүрдлийг агуулах бол, 'S' үсэг;
- (v) Баглаа боодлын иж бүрдлийг үйлдвэрлэсэн оны сүүлийн 2 орон. 1Н1, 1Н2, 3Н1 болон 3Н2 төрлийн баглаа боодлын иж бүрдлийн хувьд үйлдвэрлэсэн сарыг тэмдэглэнэ. Тэмдэглэх аргаас хамааран тэмдэглэгээг баглаа боодлын иж бүрдэл дээр өөр өөр газар тавьсан байж болно. Зохимжтой арга нь:



- (vi) Монгол Улсаас зөвшөөрснийг илэрхийлэх MN үсгүүд,
- (vii) Баглаа боодлын иж бүрдлийн үйлдвэрлэгчийн нэрэнд олгосон зөвшөөрлийн код.

*Баглаа боодлын иж бүрдлийн үйлдвэрлэгчийн зөвшөөрсөн тэмдэглэгээг энэ зүйлийн 11-д заасны дагуу тавина. Хавсралт 1-д жишээг үзүүлэв.*

**10.6** Халдвартай бодисыг агуулах баглаа боодлын иж бүрдлийг зөвшөөрсөн тэмдэглэгээ нь дараахаас бүрдэнэ:

- (a) НҮБ-ыг баглаа боодлын иж бүрдлийн тэмдэгт;
- (b) Баглаа боодлын иж бүрдлийн төрлийг тодорхойлсон код;
- (c) "Ангилал 6.2" үгс;
- (d) Баглаа боодлын иж бүрдлийн үйлдвэрлэгдсэн оны сүүлийн 2 орон;
- (e) Монгол Улсаас зөвшөөрснийг илэрхийлэх MN үсгүүд;

- (f) Баглаа боодлын иж бүрдлийн үйлдвэрлэгчийн нэрэнд олгосон зөвшөөрлийн код.

*Баглаа боодлын иж бүрдлийн үйлдвэрлэгчийн зөвшөөрлийн кодыг энэ зүйлийн 11-д заасны дагуу тавина. Хавсралт 1-д жишээг үзүүлэв.*

**10.7** Монгол Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зөвшөөрсөн тэмдэглэгээ нь дараахаас бүрдэнэ:

- (a) **TYPE A** тэмдэглэгээг А Төрлийн бүх баглаа боодол дээр; эсхүл
- (b) В төрлийн баглаа боодлын хувьд:
- (i) **TYPE B(U)** эсхүл **TYPE B(M)**-н аль тохирохыг;
  - (ii) МХЕГ-ын таних тэмдэглэгээг;
  - (iii) Тухайн баглаа боодлын иж бүрдлийн загвар дизайнд тусгайлан олгосон серийн дугаар;
  - (iv) Гал, ус, гадны нөлөөнд тэсвэртэй байхаар мөн тодорхой харагдаж байхаар тамгалсан, барласан, эсхүл өөр аргаар илэрхийлсэн гурвалсан тэмдэг.

## **11. Зөвшөөрлийн код**

**11.1** Зөвшөөрлийн код нь дараах бүтэцтэй:


- (a) МХЕГ-аас олгосон зөвшөөрлийн кодгүй баглаа боодлын иж бүрдэл дээр ИНЕГ-ын код болох САА болон ИНЕГ-аас олгосон зөвшөөрлийн дугаарыг Хавсралт 1(а)-д заасны дагуу тавина; эсхүл
- (b) МХЕГ-аас олгосон зөвшөөрлийн кодтой баглаа боодлын иж бүрдэл дээр САА үсгүүдийг Хавсралт 1 (b)-д заасны дагуу холбогдох байгууллагын кодын ард нэмж бичнэ.

## Хавсралт 1

### Техникийн үзүүлэлтийн тэмдэглэгээний жишээ

ИНЕГ-аас баглаа боодолд тавих тэмдэглэгээний жишээг дор харуулав. Тэмдэглэгээ нь нэг болон хэд хэдэн мөрнөөс бүтсэн байж болно.

(a) Зөвхөн ИНЕГ-аас зөвшөөрсөн нийлмэл баглаа боодол.

 4G/Y50/S/95/MN/CAA 12345/1

(b) Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны аюултай барааны дүрмийн Хавсралт E.2-т заасан, ИНЕГ-аас зөвшөөрсөн нийлмэл баглаа боодлын тестийн байгууллага

 4G/Y50/S/95/MN/ US 100 CAA

(US нь ISO-оос олгосон 2 үсэгт код)